

КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2023 оны 03 сарын 06-ны өдөр

№23/02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдээд хувь тэнцүүлсэн урамшуулал олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, компанийн дүрмийн 6.1.4 болон ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 6-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Крипто Үндэстэн ХК нь 2023 оны санхүүгийн жилд хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 100 (нэг зуу) ширхэг АрдКойныг хувь тэнцүүлэн олгохыг зөвшөөрсүгэй.
2. Хувь тэнцүүлсэн урамшуулал авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувь тэнцүүлсэн урамшууллыг хувьцаа эзэмшигчдийн АрдКойны дансанд 2023 оны 4-р сарын 30-ны өдөр олгосугай.
4. Урамшууллаар олгосон АрдКойн 2 (хоёр) жилийн хугацаанд түгжээтэй байх ба жил бүр 5 дугаар сарын 1-нд 50%-иар захиран зарцуулах эрх нээгдэхийг дурдсугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж, урамшуулал олгохыг Гүйцэтгэх захирал (Д.Чадраабал)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.ГАНХУЯГ